



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 11/151

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын ХҮ1.1.2.2 Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд хийгдэх ХҮ1.1.2.2.5 Эрүүл мэндийн чийрэгжүүлэлтийн талбай /Улаанбаатар, Налайх/ их засварын ажлын 57.000.000 /Тавин долоон сая/ төгрөгийн гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих санхүүжүүлэх эрхийг Нийслэлийн Налайх дүүргийн Засаг дарга /Х.Болдбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080467